



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/369

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, “Үйлдвэрлэгч-Ховд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Үйлдвэрлэгч-Ховд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулалт явуулсан ажлын хэсгийн дүгнэлт, байгуулсан гэрээ, санхүүжилтийн эрхийг үндэслэн хавсралтанд заасан аж ахуйн нэгжүүдэд зээл олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 92 800 000 төгрөг /Ерэн хоёр сая найман зуун мянган/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 3/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.16-д заасан “Үйлдвэрлэгч Ховд”, “Өрхийн жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг дэмжих” хөтөлбөрийн санхүүжилтээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилт, зээлийг зориулалтын дагуу зарцуулагдаж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
07 дугаар сарын 27-ны өдрийн
А/369 дүгээр захирамжийн хавсралт

ҮЙЛДВЭРЛЭГЧ-ХОВД" ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ОЛГОХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Төслийн нэр	Олгох зээл /төгрөг/
1.	"Саран хүрэн асга" ХХК	Буузны баншны үйлдвэрлэл өргөтгөх	5 000 000
2.	"Говь гоолингоо" ХХК	Гоолингоо оёдлын цех өргөтгөх	10 000 000
3.	Иргэн Б.Тэмүүжин	Нарийн боовны үйлдвэрлэл өргөтгөх "Өгөөж"	15 000 000
4.	Иргэн Д.Нэргүй	Төмөр эдлэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх	5 000 000
5.	Иргэн Л.Түвшинжаргал	Хоёр ихэр барс зөөлөн оёдол	10 000 000
6.	Иргэн Э.Цасчихэр	Өрлөгийн сетка, цутгалтын тор үйлдвэрлэх	5 000 000
7.	"Улаан бүрд" ХХК	Мужааны цех өргөтгөх	8 800 000
8.	Иргэн Д.Батхүү	"Жимсгэнэ-21" чацаргана, бэсрэг алим тарих, жүүс үйлдвэрлэх	8 000 000
9.	"Баян цахирын нуруу" ХХК	Эко ноосон тоглоом үйлдвэрлэх	8 000 000
10.	"Баяр хөөр түгээсэн ургац" хоршоо	Эко хүнс үйлдвэрлэх	8 000 000
11.	Иргэн Д.Тулгаа	Малын тэжээлийн аж ахуйн төсөл	10 000 000
Нийт дүн			92 800 000

-оОо-